
ᠪᠦᠭᠳ ᠨᠠᠶᠢᠷᠠᠮᠳᠠᠬᠤ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠠᠷᠳ ᠤᠯᠤᠰ᠎ᠤᠨ
ᠵᠡᠷᠭᠡ᠎ᠶᠢᠨ ᠶᠡᠪᠳᠡᠯ᠎ᠦᠨ ᠶᠠᠮ




БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЦЭРГИЙН ЯВДЛЫН ЯАМ

1924-1949

MINISTRY OF MILITARY AFFAIRS OF THE PEOPLE'S REPUBLIC OF MONGOLIA





Үндсэн хууль боловсруулах комисс. 1924 он
Commission to draft Mongolia's Constitution. 1924



Улсын анхдугаар их хурал хуралдан БНМАУ-ыг тунхаглаж, анх дугаар Үндсэн хуулийг 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр батлав.

On 26th November 1924, the First State Congress sessions declared the People's Republic of Mongolia and ratified the first Constitution.



БНМАУ-ын төр, цэргийн дээд удирдлагын бүрэлдэхүүн: Өвөр эгнээнд баруун гар талаас Ерөнхий сайд Б.Цэрэндорж, Бүх цэргийн зөвлөлийн тэргүүлэгч Н.Жадамба, Гадаад яамны тэргүүн сайд А.Амар, Бүх цэргийн жанжин Х.Чойбалсан, Улсын ерөнхий прокурор Пунцаг, Арын эгнээнд баруун гар талаас: Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга С.Гэлэгсэнгэ, ЦЯЯ-ны сайд С.Магсаржав, ..., Дотоодыг хамгаалах газрын дарга Х.Хаянхярваа нар.

State and military leaders of the PRM: front row from the right, B.Tserendorj, Prime Minister, N.Jadamba, Head of the Armed Forces Council, A.Amar, Principal Minister of Foreign Affairs, Kh.Choibalsan, Commander-in-Chief of the Armed Forces, Puntsag, State General Prosecutor, back row from the right, S.Gelegsenge, Secretary of the Central Committee of MPP, S.Magsarjav, Minister of Military Affairs, ..., and Kh.Khayankhirvaa, Chief of Internal Security.



ЦЭРГИЙН ЯВДЛЫН ЯАМНЫ САЙД НАР
MINISTERS OF THE MILITARY AFFAIRS



Сандагдоржийн Магсаржав
Magsarjav Sandagdorj
1922-1927



Сүрэнгийн Дэндэв
Dendev Suren
1927-1929



Ёндонгийн Сандагсүрэн
Sadagsuren Yondon
1929



Ламхүүгийн Дарьзав
Darizav Lamkhuu
1929-1930




Гэлэгдоржийн Дэмид
Demid Gelegdorj
1930-1937



Хорлоогийн Чойбалсан
Choibalsan Khorloo
1937-1950





БНМАУ-ын Цэргийн явдлын яамны дүрмийг 1920-иод оны сүүлчээр батлан мөрдүүлсэн байна.


Дүрэмд "БНМАУ-ын Цэргийн явдлын яам бол Бүх Цэргийн Зөвлөлийн харьяат дүрэм заавар гаргах ба элдэв зүйлийг гүйцэтгэх дээд албаны газар болох бөгөөд мөн зөвлөлөөр удирдуулан Монгол Ардын Улаан цэргийн олон хороо, анги, албаны газруудыг захирч, цэргийн хүчний байгууллага ба мөн цэрэгт элдэв зүйлийг нийлүүлэн өгөх зэрэг явдлыг эрхлэн гүйцэтгэнэ" гэж заажээ.

Charter of the Ministry of Military Affairs was approved at the end of 1920s.

The Charter stipulated that Ministry of Military Affairs of the PRM is a higher executive organization that develops related regulations and procedures of and carries out tasks and duties given by the Armed Forces Council, and under the leadership of the Council, commands and controls regiments, units and offices of the Mongolian People's Red Army and is in charge of procurement and supply of military organizations.

ЭХ ОРНОО ЧӨЛӨӨЛӨХ ЦЭРГИЙН ЭРДЭМ БОЛОВСРОЛД СУРАЛЦАЖ АРДЫН ТӨРИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР АРДЫН ЦЭРГЭЭС ТАВЬСАН ЗОРИЛГО

OBJECTIVE OF THE PEOPLE'S ARMY TO ATTAIN MILITARY EDUCATION TO SECURE THE COUNTRY AND TO PROTECT THE STATE AND GOVERNMENT



1.Ард түмнээ хамгаалах, эзэрхэг түрэмгий этгээдийг даран сөнөөх, газар орноо ариутган цэвэрлэж, хил хязгаарыг хамгаалах;


2.Ардын улаан цэргийн алив хэрэглэгдэхүүнийг засан бэлтгэх, алив нарийн сургуульд хурдан түргэн боловсруулах;

3.Ардын улаан цэргийн алба хаагчдыг алив эрдэмд боловсруулан, бичиг үсэгт сургаж гэгээрүүлэхийг зорилго болгов;

First To protect the people, destroy aggresive enemies, keep the country safe and secure the borders.

Second To repair and maintain any military item, and train personnel at rapid pace.

Third To introduce educational opportunity to the member of the service members and to make them literate and learned.




Аймгийн яамны цэргийн хэлтсийн дүрэм
1924 оны 7 дугаар сар

The Charter of the Military Department to Provinces.
July 1924.

Цэргийн явдлын яамнаас “Аймгийн яамны цэргийн хэлтсийн дүрэм”-ийг батлан мөрдүүлж, Улсыг батлан хамгаалах хэрэгт ард олныг өргөнөөр оролцуулах зорилго бүхий “Нутгийн цэргийн сургууль”-ийг явуулах болов.


The Ministry of Military Affairs approved the “Charter of the Military Departments to Provinces” and conducted “Local Military Exercise” in provinces to ensure broad participation of local population to state defense affairs.



Хан Хэнтий уулын аймгийн Эрх хошуунд цэргийн сургууль хийсэн тус хошууны ба шавийн идэр эрчүүдийн нэр, нас зэргийг тодорхойлсон бүртгэл. 1924 оны 9 дүгээр сарын 7.

The registration of the names and ages of the youth that participated the military exercise in Erkh Khoshuu Khan Khentii-Uul province. 7 Sep 1924

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙГ БАЙНГЫН ЦЭРЭГ БОЛГОХ ТАЛААР АВСАН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭ
THE MEASURES TAKEN TO TRANSFORM THE MONGOLIAN PEOPLE'S REVOLUTIONARY FORCES INTO REGULAR FORCES




МАХЦ-ийн дайчид 1925 онд Улсын баярын жагсаалын үеэр анх удаа тангараг өргөжээ.
An oath, that swore first time by soldiers of Mongolian People's Revolutionary Forces during the National Day parade. 1925






10-15 насны хөвгүүдийг зургаан жилийн хугацаатай сургах Сүхбаатарын нэрэмжит сургуулийг 1925 оны 10 дугаар сарын 10-нд байгуулав.
School named after Sukhbaatar was established to train boys aged 10-15 years old for six years. 10 Oct 1925

ЦЭРГИЙН ЕРӨНХИЙ СУРГУУЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
STRUCTURE AND ORGANIZATIONAL CHART OF THE MILITARY SCHOOL



Цэргийн ерөнхий сургуулийн захиргаа, аж ахуйн бүтэц. 1925 он

The organizational chart of the Administration and logistics of the Military School. 1925



Цэргийн ерөнхий сургуулийн сурах ангийн бүтэц. 1925 он

The organizational chart of the Training Division of the Military School. 1925




Нисэх хүчний ангийг байгуулав. 1925 он.

Air force unit was established. 1925



Цэргийн төрөл бүрийн дүрмүүдийг батлан гаргаж мөрдүүлэв. 1925 он.
Various military field manuals and instructions approved,1925.



ЦЯЯ-ны дэргэд байгуулагдсан
“Жавхланг бадруулагч”
эвлэлийн үүрийн гишүүд
Members of the Union
“Splendor” established under
the MMA.



Улсын III их хурлаас Ардын улаан цэргийн 70 хувийг бичиг үсэгтэй болгох зорилт дэвшүүлжээ. 1926 он.

The 3rd State congress set the goal to reach 70 percent literacy rate of members of the People's Military Troops. 1926

"Хувьсгалт улаан цэргийн бодлого" сэтгүүл гарч эхлэв. 1928 он.

Magazine "Policy of the Revolutionary Military Troops" began to publish. 1928



Арын албаны анхдугаар курс төгсөгчид. 1937 он

Graduates of the first Logistics course. 1937

1933 онд Цэргийн ерөнхий сургуулийн дэргэд академийн курс, Цэргийн госпиталийн дэргэд хүний бага эмч нарыг бэлтгэх нэг жилийн,1934 онд Их бууны мэргэжилтэн бэлтгэх 8 сарын курс, 1935 оноос Нисэх хүчний сургууль, 1936 оноос Мал эмнэлгийн сургууль, 1937 оноос Сүхбаатарын нэрэмжит Цэргийн сургуулийг тус тус байгуулав

In 1933, Academy courses at the Military school and one-year nurse course at the Military hospital, in 1934 eight-month artillery specialist course, in 1935 Air Force School, in 1936 Veterinary School, and in 1937 Military Cadet School named after Sukhbaatar were established.

ЦЭРГИЙН ЯВДЛЫН ЯАМНЫ БОЛОВСОН ХҮЧНИЙ СУРГАЛТ БЭЛТГЭЛ
TRAINING FOR PERSONNEL OF THE MINISTRY OF MILITARY AFFAIRS



ЗХУ-д нисэхийн сургууль төгсөгч Лхамхүү, Ч.Шагдарсүрэн нар

Lkhamkhuu and Ch.Shagdarsuren, graduates from the Air Force School of the Soviet Union



Тверь хотын Морин цэргийн дунд сургууль төгсөгчид Монгол ардын хувьсгалт цэргийн удирдах бүрэлдэхүүнийг бүрдүүлж байв. Зүүн гар талаас: Г.Дэмид, Б.Гончигшарав, Э.Гочоо, Г.Самбуу нар.

Graduates from the Trooper school of Tver city were main body of leadership of the Mongolian People's Revolutionary Troops. From the left: G.Demid, B.Gonchigsharav, E.Gochoo and G.Sambuu.



ЗХУ-ын Цэргийн командлах бүрэлдэхүүнийг бэлтгэдэг академид анх Х.Чойбалсан,С.Цэрэнгомбо нарын хүмүүс явж суралцсанаар цэргийн боловсон хүчнийг гадаадад бэлтгэх эхлэл тавигджээ. 1923 он

Kh.Choibalsan and S.Tserengombo were studied in Soviet military academy was the beginning of the military personnel trained in abroad. 1923



ЗХУ-д суралцсан Танкийн сургуулийн монгол сурагчид
Mongolian students of Armour school in the Soviet Union.



ЗХУ-ын Тверь хотын цэргийн сургуульд давтан курс төгсөгчид. 1932 он
Graduates from the Military School in Tver city of the USSR. 1932



Цэргийн сургуулийн сурагчид Cadets of the Military School



Пулеметын хичээл дээр At the machine-gun training



Цэргийн сургуулийн сурагчид их бууны бие ангийг судалж буй нь Cadets of the Military School at artillery training


1921-1937 ОНЫ ҮЕИЙН МАХЦ-ИЙН БАЙЛДААНЫ ЗЭВСЭГ ТЕХНИК
WEAPONS AND MILITARY EQUIPMENTS OF MONGOLIAN PEOPLE'S REVOLUTIONARY TROOPS FROM 1921-1937



Хуягт танкийн анхны анги салбар байгуулагдав.1923 он
The first armour units were established. 1923



1925 онд анхны нисэх онгоц бууснаар Монголын нисэх хүчний суурь тавигдаж, 1937 он гэхэд нисэхийн хоёр хороотой болов.
The first aircraft landed in Mongolia in 1925 and two regiments of the Air Force were founded. 1937




Цэргийн зэвсэглэлд байсан “Т-27” танкетик. 1932 он
“Т-27” tank which was in Military arsenal. 1932



Их буучид
Artillerists



Байлдааны дунд хуягт машин
Armoured vehicle



Цэргийн хэвлэх үйлдвэр 1930-аад он
Military printing factory in the 1930s



1 дүгээр дивизионы намын бага хурлын төлөөлөгчид. 1930 он
Delegates from 1st Battalion participated in Political conference. 1930



Монголын төр, цэргийн удирдлагууд МАХЦ-ийн дивиз хороо, ангийн дарга, улс төрийн ажилтнуудын хамт. 1933 он

State and military leaders with division, regiment and unit commanders and political officers of Mongolian People's Revolutionary Military Forces,1933



Цэргийн явдлын яамны удирдах бүрэлдэхүүн. 1934 он.
Өвөр эгнээнд зүүн гар талаас: Бүх цэргийн бэлтгэлийн газрын дарга Д.Гончиг, Жанжин штабын дарга Ж.Малж, арын эгнээнд зүүн гар талаас: Бүх цэргийн жанжны орлогч Л.Дарьзав, Жанжин штабын орлогч Т.Дашзэвэг, Цэргийн явдлын яамны сайд, Бүх цэргийн жанжин Г.Дэмид, Цэргийн улс төрийн газрын дарга Д.Өлзийбат

Leaders of the Ministry of Military affairs. 1934
Front row from left: D.Gochig, Head of the Military Training Department, J.Malj, Chief of the General Staff Back row from left: J.Darizav, Deputy Commander of the Military Forces, G.Demid, Minister of Military of affairs and Commander of the Military Forces, D.Ulziibat, Chief of the Military Political Department



Өвөр эгнээнд Улс төрийн газрын дарга, Армийн ерөнхий комиссар О.Дашчарви, Цэргийн явдлын яамны сайд, Бүх цэргийн жанжин, маршал Г.Дэмид, Бүх цэргийн жанжны орлогч, корпус командлан захирагч Г.Самбуу, ар эгнээнд 5-р морьт дивизийн дарга, бригад командлан захирагч Ж.Даваажаргал, 6-р морьт дивизийн дарга, дивиз командлан захирагч Б.Гончигшарав, Монгол ардын хувьсгалт цэргийн Жанжин штабын дарга, корпус командлан захирагч Ж.Малж, Дорнод 2-р корпусын дарга, корпус командлан захирагч Г.Дамба, Цэргийн явдлын яамны Их бууны газрын дарга, дивиз командлан захирагч Г.Жанцанхорлоо.

In the front row, Chairman of the Office Political Affairs O.Dashcharvi, Minister of the Military Affairs and Commander of the Military Forces, Marshal G.Demid, Deputy Commander of the Military Forces, Corps Commander G.Sambuu, in the back row, Commander of the 5th Cavalry Division, Brigadier Commander J.Davaajargal, Commander of the 6th Cavalry Division, Division Commander B.Gonchigsharav, Commander-In-Chief of the Mongolian People's Revolutionary Military Forces, Corps Commander J.Malj, Commander of the 2nd Dornod Corps, Corps Commander G.Damba, Chief of the Artillery Department of the Ministry of the Military Affairs, Division Commander G.Jantsankhorloo.



МАХН-ын Төв хороо МАХЦ-ийн байлдааны ба улс төрийн бэлтгэлийн амжилтанд баяр хүргэж дурсгасан улаан тугийг хүлээн авч байгаа нь Зүүн гараас: Улс төрийн газрын дарга Д.Наваанлувсан, НТХ-ны тэргүүлэгч Раднаабазар, Бадам-Иш, Бүх цэргийн жанжин Г.Дэмид. 1931 он

The Central Committee of the MPRP congratulated to achievements in the battles and political training and received the Red Banner. 1931




Монгол Ардын Хувьсгалт цэрэг нь орчин үеийн европ маягийн бүтэц зохион байгуулалттай болсон ч үндэсний өв уламжлалаа сэргээн хадгалж байсан юм.

Although the Mongolian People's Revolutionary Military Forces formed into modern European-style structure, it kept its traditions.



Морьт цэргүүд. 1930-1938 он
Cavalries. 1930-1938



Ардын хувьсгалын ялалтын 10 жилийн ойн үзэсгэлэн
Exhibition dedicated to the 10th anniversary of the Victory of the People's Revolution.




1936 оны Манжуурын бага хуралд оролцсон Монгол, Япон, Манж-Гогийн төлөөлөгчид.
БНМАУ-ын Засгийн Газрын төлөөлөгчдийг ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 2 дугаар орлогч Г.Самбуу даргалж оролцсон юм.

Mongolian, Japanese, and Manchu-Go delegates attended the Manchurian conference of 1936.
Delegates of the Government of the Mongolian People's Republic led by the Minister of Military Affairs and the Deputy General of the Military Forces, G.Sambuu, attended the conference.



Халхын сүм 1930-аад он
Temple of Khalh, in the 1930s



Булан дэрс, Адагдулаан, Ар шаврын харуулуудын хийсэн байлдаан.
1936 оны 3 дугаар сарын 31-ний өглөө
Battle by guards of Bulan ders, Adagbulan, Ar shahvar.
morning of 31 March 1936



Л.Дэмбэрэл, Г.Дэмид, Х.Чойбалсан, Д.Содномдаржаа. 1930-д оны эхэн үе
L.Demberel, G.Demid, Kh.Choibalsan and D.Sodnomdarjaa, in the early 1930



Корпусын шүүгч Ө.Чулуун сургагч нарын хамт.
Corps Judge, U.Chuluun with Instructors

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН ДҮРЭМТ ХУВЬЦАС 1936-1944


UNIFORM OF THE MONGOLIAN PEOPLE'S REVOLUTIONARY MILITARY FORCES






Маршал (Өрлөг жанжин) | Дэслэгч жанжин | Корпус командлан захирагч | Дивиз командлан захирагч | Бригад командлан захирагч






Хурандаа | Дэд хурандаа | Хошууч | Ахмад



Ахлах дэслэгч | Дэслэгч | Бага дэслэгч




Жагсаалын дарга | Ахлах түрүүч | Түрүүч | Бага түрүүч



Байлдагч


Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн Ардын сайд нарын зөвлөлийн 1936 оны 02 дугаар сарны 21-ний өдрийн хамтарсан хурлын 14 дүгээр тогтоолоор МАХЦ-ийн дарга улс төрийн ажилчдад олгох цэргийн цолыг бий болгосны зэрэгцээ Ардын хувьсгалт цэргийн командлах ба захирах тушаалтны алдар цолд тохируулан хувцас ба тэмдгийн загварыг баталж, Монгол Улсад цэргийн цолыг жинхэнэ ёсоор бий болгох, хэрэглэж эхлэх үндэс тавигдсан юм.

The Resolution No.14 made at the joint-conference of the board of the People's ministers of the State Baga Hural Representatives on 21 February 1936 enables the issuance of military ranks to commanders of the MPRMF and government officers. In addition to, shape and design of uniform and insignia in coherence with titles and ranks of personnel of the People's Revolutionary Military Forces to command and order were approved, which lead to the basics of creating and starting to use the military ranks officially in Mongolia.



Цэргийн явдлын яамны сайд,
Бүх цэргийн жанжин,
маршал Гэлэдоржийн Дэмид

Minister of Military Affairs and
Commander of the Military Forces,
Marshal Demid Gelegdorj



Жанжин штабын дарга,
корпус командлан захирагч
Жигдэнгийн Малж

Chief of General Staff,
Corps Commander Malj Jigden



БНМАУ-ын баатар
Шагдарын Гонгор

Hero of Mongolian People's Republic,
Gongor Shagdar




БНМАУ-ын агаарын Зоригт баатар нисгэгч
Дамчайн Дэмбэрэл

Bravery hero pilot of Mongolian People's Republic
Demberel Damchai



БНМАУ-ын эрхэм нисгэгч
Чоймболын Шагдарсүрэн

Honoured pilot of Mongolian People's Republic
Shagdarsuren Choimbol




Зүүн хязгаараар 1936 онд халдсан Япон, Манж-го цэргийн довтолгоог МАХЦ-ийн дайчид няцааж, цохисон бөгөөд эдгээр байлдааны ажиллагааг ЦЯЯ сайд, Бүх цэргийн жанжин Г.Дэмид өөрийн биеэр төлөвлөн удирдав.


The attack of Japan and Manchu-Go in eastren border defeated by Mongolian People's Revolutionary Military Forces which led by G.Demid, Minister of Military Affairs and Commander of the Military Forces.1936



Маршал
Гэлэгдоржийн Дэмид
Marshal
Demid Gelegdorj



Цэргийн ерөнхий комиссар
Дуламсүрэнгийн Дашчарви
Military General Commissar
Dashcharvi Dulamsuren



Корпус командлан захирагч
Жигдэнгийн Малж
Corps commander
Malj Jigden



Корпус командлан захирагч
Гончигийн Самбуу
Corps Commander
Sambuu Gonchig



Корпус командлан захирагч
Лхамхүүгийн Дарьзав
Corps Commander
Darizav Lhamkhuu



Дэслэгч жанжин
Готовын Дамба
Lieutenant Commander
Damba Gotov



Корпусын комиссар
Гэндэнжавын Лут-Очир
Corps Commissar
Lut-Ochir Gendenjav



Корпусын комиссар
Дэндэвийн Наваанлувсан
Corps Commissar
Navaanluvsan Dendev



Корпусын комиссар
Жаргалын Галдан
Corps Commissar
Galdan Jargal



Корпусын комиссар
Гүнжидийн Найдан
Corps Commissar
Naidan Gunjid

БНМАУ-ын баатар зоригт улаан цэргийн их жанжин туг

Great Command Flag of the Red Army of the PRM

ДАЙНЫ ЖИЛҮҮДИЙН ЦЭРГИЙН ЯВДЛЫН ЯАМ

MINISTRY OF MILITARY AFFAIRS DURING THE WAR TIME

1939 оны Халхын голын дайн,1945 оны Чөлөөлөх дайн, 1940-1948 оны Баруун хилийн зэвсэгт тулгаралтад Монгол Ардын Хувьсгалт Цэргийн ангиудыг ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжин, маршал Х.Чойбалсан ерөнхийд нь удирдаж, фронтын удирдлагыг ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны орлогч Ц.Лувсандоной, Ж.Лхагвасүрэн нар удирдаж байв.

Marshal Kh.Choibalsan, Minister of Military Affairs, Commander-in-Chief was in charge of the MPRMF during the War of Khalkhin Gol in 1939, War of Liberation in 1945 and Armed conflict in western border in 1940-1948 and field command duties had been vested to Ts.Luvsandonoi, and J.Lkhagvasuren, Deputy Commander-in-Chief.




Цэргийн явдлын яамны сайд,
Бүх цэргийн жанжин,
маршал Х.Чойбалсан

Minister of Military Affairs,
Commander-in-Chief,
Marshall Kh.Choibalsan



Бүх цэргийн жанжны орлогч,
корпус командлан захирагч
Ц.Лувсандоной

Deputy Commander in Chief,
Corps Commander Ts.Luvsandonoi



Монгол ардын хувьсгалт цэргийн улс
төрийн газрын дарга,
корпусын комиссар Ж.Лхагвасүрэн

Chief of Political Department of the MRPMF
Corps Commissar J.Lkhagvasuren






1935 оноос эхэлсэн Монгол, Манж-Го-ийн хооронд хилийн будлиан тасралтгүй үргэлжилсээр 1939 оны 5 дугаар сар гэхэд Японы цэргийн командлал Халхын голын орчим нутагт цэргээ төвлөрүүлж эхэлжээ. 5 дугаар сарын 11,12-нд болсон хилийн тулгаралтын дараагаар Дунд овооны баруун талд байрлаж байсан БНМАУ-ын хилийн 7 дугаар заставыг японы нисэх онгоц 5 дугаар сарын 15-нд бөмбөгдөв. 5 дугаар сарын 28-ны үүрээр японы 40 орчим онгоц манай цэргийн байршлыг бөмбөгдөн, давшилтад орсноор Халхын голын дайн эхэлжээ.

The border conflicts between Mongolia and Manchu-Go began since 1916 had been continuously up to May 1939 when the Japanese military command began to concentrate its troops in the area of Khalh Gol. Shortly after the border attack commenced on 11 and 12 of May, the Japanese aircraft bombed the 7th border post of the PRM settled in the west of Dund-Ovoo. In the dawn of May 28, the bombardment of about 40 jets on our military positions and the offense of Japanese military attack led to start the War of Khalhin Gol.






Агаарын тулаан ба дэлхийн дайны түүхэнд бичигдсэн үйл явдал.
Aerial warfare and battles written in the World War History



Халхын голын дайны явцад 6 дугаар сарын агаарын байлдаан, дэлхийн хоёрдугаар дайны өмнөх танкийн хамгийн том тулалдаан болох 7 сард болсон Баянцагааны тулалдаан зэрэг томоохон байлдаанууд болж, Монгол-Зөвлөлтийн цэргийн 8 дугаар сарын 20-ны ерөнхий давшилтын дүнд Хамардаваа-Номунханы чиглэлд Японы 6 дугаар армийг бут цохив.

During the War of Khalhin Gol, the great battles, including Aerial warfare of the month of June and battle of Bayantsagaan of the month of July which was the biggest battle of tank units prior to the World War II, occured. On August 20, the Japanese 6th Army was defeated in result of offensive campaign of Mongol-Soviet Military Forces in direction of Khamardavaa-Nomunkhan.



Хуягтын жолооч, БНМАУ-ын баатар Д.Хаянхярваа сургагч багшийн хамт
Operator of armoured vehicle, the Hero of PRM D.Khayankhyarvaa with his instructor



Дивиз командлан захирагч Ж.Цэрэн,
корпус командлан захирагч Ж.Лхагвасүрэн нар
Division Commander J.Tseren and
Corps Commander J.Lkhagvasuren











"Эх орны төлөө" сонины эрхлэгч С.Равдан
Editor, newspaper "For Motherland"
S.Ravdan



Халхын голын дайны үед "Эх орны төлөө" сонины 80 удаагийн дугаар гарсан байна.
"For motherland" newspaper was published in 80 times during the War of Khalkhiin gol





1939 оны 5 дугаар сараас 9 дүгээр сарын 15-ны агаарын байлдааныг хүртэл 4 сар үргэлжилсэн энэ дайнд нэг талаас ЗХУ, БНМАУ, нөгөө талаас Япон, Манж-Го гэсэн дөрвөн улсын 132 мянган цэрэг, офицер, 1000 гаруй танк, хуягт машин, 800-аад нисэх онгоц оролцжээ.

132 thousand troops and officers, over 1000 armoured-vehicles and tanks, and about 800 aircrafts of four countries, including the USSR-Mongolia on one side, and Japan-Manchu-Go on another side, took part in this war which lasted for 4 months, from 9 May 1939 to the Aerial Battle of September 15.

ХАЛХЫН ГОЛЫН ДАЙНААС ТӨРСӨН МОНГОЛ УЛСЫН БААТРУУД
MONGOLIAN HONOURED HEROES OF THE WAR OF KHALHIN GOL


Ш.Гонгор


Л.Дандар


Ж.Лхагвасүрэн


Л.Гэлэгбаатар


Ц.Олзвой


Ч.Дугаржав


С.Төмөрбаатар


В.Шарав


Н.Жамбаа


П.Чогдон


Э.Шийлэг


Д.Гуулин


Д.Самдан


М.Экей


Д.Нянтайсүрэн













МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ю.Цэдэнбал, Батлан хамгаалах яамны сайд, армийн генерал Б.Дорж БНМАУ-ын баатрууд болон армиас төрсөн алдартнуудын хамт. 1979 он

Yu.Tsedenbal, General Secretary of the MPRP and Chairman of the PGH Representatives Army General B.Dorj, Minister of Defense with Heroes of the PRM and military high ranking officers. 1979



Бэлэглэлийн төв комисс
The Central Commission for Endowment





БНМАУ дайн эхэлсэн анхны өдрөөс ЗХУ-ын талд тууштай зогсож, ард олон Улаан армид туслах бүх нийтийн хөдөлгөөнийг өрнүүлсэн.1941 оны 9 дүгээр сарын 6-нд бэлэглэлийн ажлыг эрхлэх Засгийн газрын комисс байгуулагдаж, даргаар БНМАУ-ын ГЯЯ-ны орлогч сайд Э.Намсрай, МАХН-ын Төв хорооны тэргүүлэгч гишүүн С.Янжмаа нар ажиллаж байв.

Mongolia was strongly on side of the Soviet Union since the first day of Motherland War began and launched a public movement to assist the Red Army. On 6 September 1941, the Commission of Government which undertake activities on endowing, was formed and chaired by E.Namsrai, Deputy Minister of the Foreign Affairs of the PRM and S.Yanjmaa, Leading Member of the Central Committee of the PPRP.

Улаан армид туслах олон хэлбэрийн ажлыг өрнүүлсний дүнд нийтдээ 435 сая төгрөгийн үнэ бүхий мал, эд материалын зүйл ба 300 орчим кг алтыг биетээр өгч, 485,000 морьд худалдаж, 32,500 гаруй шилдэг хүлгийг фронтод бэлэглэжээ. Монголын ард түмний хөрөнгөөр байгуулагдсан “Хувьсгалт Монгол” танкийн бригад нь ЗХУ-д үйлдвэрлэсэн Т-34 танк 32, Т-70 танк 21, нийт 53 танктай, “Монгол Ард нисэх эскадриль” нь “Ла-5” загварын 12 нисэх онгоцтой байв.

As a result of a variety of activities on helping the Red Army, livestock and items at value of MNT 435 million, about 300 kg of gold as a gift handed over, 485,000 horses were sold, and over 32,500 best horses were gifted to fronts. Brigade of tank “Revolutionary Mongol”, established by stock of the Mongolian people, consisted of a total number of 53 tanks, including 32 of T-34 tank and 21 of T-70 tank, “Mongol Ard Air Squadron” consisted of 12 of “La-5” model aircrafts.







Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын харьяат С.Цэгмэд 1942 онд 18 настайдаа фронтод Монголын ард түмний бэлгийг хүргэж өгч байжээ.

S.Tsemed, Saikhan-Ovoo soum, Dundgovi province, delivered the gifts of Mongolia's People to the front at age of 18 in 1942.




Олноо "Фронт Цэгмэд" хэмээн алдаршсан С.Цэгмэд. 2021 он
S.Tsegmed , Honourly titled "Front Tsegmed". 2021



Төр, засгийн зүгээс ард түмэнд дайны хор уршиг, Чөлөөлөх дайны ач холбогдлын талаар ухуулан таниулах ажлыг зохион байгуулж буй нь



The propaganda activities of Government on loss and damage caused by wars and significance of the Liberation War



Улаан цэрэгт морь бэлэглэсэнд олгох үнэмлэх. 1943 он
The certificate of issuanse of gift horses to Red Army.1943



Фронтод морь бэлэглэж байгаа нь. 1943 он
Presenting gift horses to the front. 1943

МОНГОЛЫН АРД ТҮМЭН

БҮХНИЙГ ФРОНТОД
БҮХНИЙГ ЯЛАЛТЫН
ТӨЛӨӨ



Монголын ард түмний чин сэтгэл, цаг наргүй хөдөлмөрөөр бүтсэн 6 удаагийн бэлгийн цуваагаар нийт 567 вагон


Мах 680,1тн


Хиам 254,8тн


Гурилан бүтээгдэхүүн 93,5тн


Тос 241,01тн


Эдийн саван 80,6тн


Архи 10,5тн


Цэрэг бүс 46800ш


Бусад гутал /хос/ 63783ш


Казах эмээл 1600ш


Эсгий гутал /хос/ 88450ш


Ороолт 2000ш


Загас 65023кг


Буга 4ш, /тураг мах/


Ятууны мах 3646ш


Чихэр 36900кг


Зээр 57927ш+44тн /тураг мах/


Дах 6766ш


Үстэй хантааз 64233ш
Хөвөнтэй хантааз 3066ш


Үстэй бээлий /хос/ 31257ш


Богино нэхий дээл 67635ш


Нэхий хөнжил 3321ш


Эсгий гэр 194ш


Унадаг дугуй 628ш


Гэрийн эсгий 7836м


Танкийн малгай 276ш


Цаначны малгай 900ш


Зэрлэг гахайн мах 15,6тн+715ш


Чанамал жимс 12954кг


Тамхи 8849ш


Бичгийн дугтуй 56050ш
Өврийн дэвтэр 60325ш


Нийтийн бэлэг 127 авдар
Хувийн бэлэг 55609ш

НИЙТ ДҮН НЬ 41 630 978 ТӨГРӨГ БОЛЖЭЭ





Аугаа их Эх орны дайнд Монгол морьдын үнэлж баршгүй их хувь нэмэр, дурсгалыг хүндэтгэн Ялалтын баярын 75 жилийн ойгоор "Ялалтад тэмүүлсэн Монгол морьд" хөшөөг ОХУ-ын Москва хотноо босгосон юм. 2020 он

On the occasion of the 75th Anniversary of Victory, "The Mongolian horses for Victory" statue, in the memory of valuable contributions of the Mongolian horses to the Great War for the Motherland, was erected in Moscow city of the Russian Federation. 2020



Сайн дурын морьт отрядын дарга жанжин Ч.Мижид
Volunteer Cavalry Division Commander. Ch.Mijid



Сайн дурын морьт отрядын штабын дарга В.Даржаа
Volunteer Cavalry Division Commander. B.Darjaa

МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчдийн 1942 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн XIX хурлын шийдвэрийн дагуу Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядуудыг аравт, тавьт, зуут, мянгат, түмтийн бүтэцтэйгээр зохион бийгуулав.

People's self defense voluntary cavalry units of 10th, 50th, 100th, 1000th and 10000th were formed by the de- cision of the MPRP central committee 24 Feb 1942





Морьт отрядын хээрийн сургууль
дээр маршал Х.Чойбалсан
At Cavalry Division Filed Training
Marshal.Kh.Choibalsan









Морьт отрядын дайчдын хээрийн сургууль, Зоргол хайрхан

Field Training for Cavalry Division Troops Zorgol Hairhan (Mountain)

АНХНЫ ГЕНЕРАЛ ЦОЛТНУУД
THE FIRST GENERALS



Дэслэгч генерал Ю.Цэдэнбал — Lieutenant General Yu.Tsedenbal



Дэслэгч генерал Ж.Лхагвасүрэн — Lieutenant General J.Lkhagvasuren



Хошууч генерал Д.Дамдинхүү — Major General D.Damdinhuu



Хошууч генерал С.Равдан — Major General S.Ravdan



Хошууч генерал Б.Дорж — Major General B.Dorj



Хошууч генерал Г.Рэндоо — Major General G.Rendoo



Хошууч генерал С.Балдан — Major General S.Baldan



Хошууч генерал Р.Осор — Major General P.Osor



Хошууч генерал Г.Дагдан — Major General G.Dagdan




Хошууч генерал М.Зайсанов — Major General M.Zaisanov




Хошууч генерал Б.Шагдаржав — Major General B.Shagdarjav

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 22 дугаар тогтоолоор МАХЦ-ийн нийт дарга нарыг офицер хэмээн нэрлэж, нийт албан хаагчдын алдар цолыг шинэчлэв.МАХЦ-т цэргийн шинэ цол нэвтэрч, “Эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг батлан хамгаалах үйл хэрэгт онц гарамгай гавьяа байгуулсан цэргийн дээд дарга нарт олгоно” хэмээн журамлан “Генерал” хэмээх эрхэм хүндтэй цэргийн дээд цолыг БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 52 дугаар тогтоолоор 11 хүнд генерал цол анх олгосноос хойш эдүгээ нийт 196 алтан мөрдэст генерал төржээ.


On the Resolution of #22 of 18 April 1944 of the Representatives of Baga Khural of PRM, all ranks of commanders were named officers and all insignias of military personnel of MPRMF were renewed. New military rank was introduced in MPRMF and on the Resolution of #52 of 28 April 1944 of Ministers Counsil of PRM, 11 officers were promoted to the rank of General and since then the number of 196 officers were promoted to General.




Цэргийн явдлын яамны сайд, Бүх цэргийн жанжин маршал Х.Чойбалсангийн 1945 оны 7 дугаар сарын 21-ны ба 8 дугаар сарын 2-ны өдрийн тушаалаар МАХЦ-ийн Өмнөд бүлгийн командлагч бөгөөд өөрийн орлогчоор дэслэгч генерал И.А.Плиевийг, Өмнөд бүлгийн командлагчийн монгол цэрэг хариуцсан орлогчоор дэслэгч генерал Ж.Лхагвасүрэнг тус тус томилжээ.



On the orders of 21 July and 2 August of Marshal Kh.Choibalsan, Minister of Military Affairs and Commander-in-Chief, Lt.General I.A.Pliev was appointed as a Commander of the South group and a Deputy Commander of the Military Forces and Lt.General J.Lkhagvasuren as Deputy Commander of the South Group in charge of Mongolian forces respectively.



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурал ба Засгийн газраас Японд дайн зарлах тухай тунхаглах бичиг. 1945.08.10
Official letter for Declaration of War to Japan issued by Baga Khural and Government of PRM. 10 August 1945.



Чөлөөлөх дайнд анги, салбар удирдсан зарим дарга нар.
Өвөр эгнээнд зүүн гараас: Д.Нянтайсүрэн, Ё.Төрхүү, Д.Самдан, Ж.Дагва, З.Дагвадорж, арын эгнээнд зүүн гараас: Д.Гомбосүрэн, Ё.Содномдаржаа, Санзай, Р.Чүлтэм

Commanders of Units took part in Liberation War.
Front row from left: D.Nyantaisuren, Yo.Turkhuu, D.Samdan, J.Dagva, Z.Dagvadorj, Back row from left: D.Gombosuren, Yo.Sodnomdarjaa, Sanzai, R.Chultem






МАХЦ-ийн морьт ангиуд Их Хянганы нурууг давж буй нь 1945 оны 8 дугаар сар
Cavalry units of MPRMF are climbing over the Ikh Khyangan mountain. Aug 1945.




Ар тал хангалтыг хүнд бэрх замыг туулан хүргэж байлаа.
Logistics and supply were provided with challanges and difficulties.





Чөлөөлөх дайны үеийн ухуулах хуудсууд.
Propaganda posters provided during the Liberation War.



БНМАУ-ын -ын баатар С.Дампил, Д.Данзанваанчиг

Heroes of the PRM, S.Dampil and D.Danzanvaanhig



Өмнөд бүлгийн командлагчийн Монгол цэрэг хариуцсан орлогч дэслэгч генерал Ж.Лхагвасүрэн анги, дивизийн удирдлагын хамт.

Leitunant General, Deputy Commander in charge of Mongol Troops of the South Group Commanders, J.Lkhagvasuren with unit and division management. 1945



Ялалт хөшөө
Ц.Амгалан, зэс, 1984 он
Монгол цэргийн музей

The Victory Statue
Ts.Amgalan
Brass.1984
The Mongolian Military Museum



МАХЦ-ийн ангиудын оролцсон томоохон байлдаан Жанчхүүгийн даваанд 1945 оны 8 дугаар сарын 19-21-нд болсон юм.

Major battle engaged by the units of MPRMF occured on Janchhuugyn Davaa, 19-21 August 1945.






Долнуурт болсон чөлөөлөх дайны ялалтын цуглаан. 1945 он

1945 оны Чөлөөлөх дайны удирдлагын бүрэлдэхүүн

Management Team in the Liberation War of 1945



Victory meeting after the Liberation War at Dolnuur. 1945

БНМАУ-ЫН ТУСГААР ТОГТНОЛЫН ТӨЛӨӨХ БҮХ НИЙТИЙН 1945 ОНЫ 10 ДУГААР САРЫН 20-НЫ САНАЛ ХУРААЛТ

THE REFERENDUM FOR INDEPENDENCE OF MONGOLIA

"Firmly hope that you all esteem the Freedom and Independence that kept for you."
Marshal Kh.Choibalsan

"Эрхэмлэж яваарай хэмээн машид итгэн эрх чөлөө тусгаар тогтнолыг та нарт үлдээв."
Маршал Х.Чойбалсан.








1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр явагдсан бүх нийтийн санал асуулгад нийт 494,074 хүн бүртгэгдсэнээс 487,285 хүн буюу нийт сонгогчдын 98,6 хувь нь БНМАУ-ын тусгаар тогтнолын төлөө саналаа өгч түүхэн сонголт хийсэн юм.
The Referendum was taken place in 20 October 1945 and 487,285 people (98.6%) out of a total number of 494,074 people that registered made a historic choice and voted for the Independence of PRM.







ЦЯЯ-ны сайд, маршал Х.Чойбалсан,
Хасгийн дээрэмчдийн толгойлогч Оспан нар. 1944 он.
Marshal Kh.Choibalsan, Minister of Military Affairs,
with Ospan, Leader of Khasag plunders. 1944



БНМАУ-ын баруун хилээр хасгийн дээрэмчид болон хятадын гоминданы цэргүүд өдөөн хатгалга үйлдэж, тайван бус байдал бий болсонтой холбогдуулан Ховд дахь МАХЦ-ийн 4 дүгээр морьт хороонд хүч нэмэгдүүлж, ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны орлогчийн 1944 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 030 дугаар тушаалаар Казак үндэстнээс бүрдсэн 25 дугаар тусгай морьт хороог Ховдод байгуулж, мөн оны 4 дүгээр сард Өндөрхаанд байрлаж байсан 6 дугаар морин бригадыг Ховдын Үенчид марш үйлдүүлэн шилжүүлэн байрлуулжээ.

Баруун хилийн тулгаралтаас төрсөн баатрууд. 1948 он
Heroes from the Armed conflict at Western Border. 1948



Лхүнрэв Даваадорж (1926-1948)

Davaadorj Lkhundev



Баянбал Тэгшээ (1926-1948)

Tegshee Bayanbal



Бэгз Гиваан (1926-1948)

Givaan Begz



Байтаг богдын зэвсэгт тулгаралт. 1947.06.05
Armed conflict at the mountain of Baitag bogd. 05 June 1947.

ДАЙНЫ ДАРААХ МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРЭГ
MONGOLIAN PEOPLE'S REVOLUTIONARY MILITARY FORCES POST WAR



Цэрэг дайчид шинэ үсэгт суралцаж байгаа нь.
The troops are learning new Mongolian alphabets.



БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1946 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 16 дугаар хурлын тогтоолоор Цэргийн явдлын яамны шууд харьяанд Агаарын иргэний нисэх онгоцны отрядыг байгуулж, түүнд "Супер" онгоц 5, ПО-2 онгоц нэгийг шилжүүлжээ.

The Ministers Council's of PRM issued the resolution on 7 Mar 1946 to establish the "Civil aviaition unit" under the Ministry of Military Affair command and control and handed over 5 "Super" and 1 "PO-2" planes.



Цэргийн явдлын яамны сайд, Бүх цэргийн жанжин, маршал Х.Чойбалсаны МАХЦ-ийн ойн баярын өдрийг жил бүрийн 3 дугаар сарын 18-нд тэмдэглэж байх тухай хүсэлтийн дагуу БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1946 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 32 дугаар тогтоолоор "МАХЦ-ийн баярын өдөр"-ийг тэмдэглэх тухай шийдвэрийг гаргасан бөгөөд энэхүү баярыг 1947 оноос ёслол төгөлдөр тэмдэглэж байна.

In accordance with request of Marshal Kh.Choibalsan, Minister of Military Affairs and Commander-in-Chief, to celebrate the anniversary day of the MPRMF on 18 March of each year, the Resolution #32 on celebration of the anniversary day of MPRMF was released on the meeting held by Baga Hural Representatives of the PRM on 28 May 1946 and Mongolian Military Day has been officially celebrated on March 18 annually since 1947.

ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх Цэргийн жанжны 1945 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн тушаалаар МАХЦ-ийн нийт анги нэгтгэл, албан байгууллагыг 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс тайван цагийн бүтэц, зохион байгуулалтад шилжүүлж, Барилгын цэргийг байгуулав.

The Minister of Military Affairs, Commander-in-Chief issued the order on 7 Nov 1945 to transfer the military units and other organizations to the structure of peace time and established construction troops from 1 Jan 1946.




БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1947 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн "Сүхбаатарын нэрэмжит офицерын сургуулийн барилгыг бариулах тухай" тогтоол, ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны орлогчийн 1947 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 145 дугаар тушаалаар 26 дугаар барилгын батальон буюу одоогийн Зэвсэгт хүчний 017 дугаар ангийг байгуулжээ.

Тус анги байгуулагдсан анхны жилдээ маршал Х.Чойбалсангийн өргөө, Офицерын сургуулийн барилга (одоогийн Хөдөө аж ахуйн их сургууль), Улаанбаатар, Өндөрхаанд мөсөн зоорь, Цэргийн явдлын яамны 16 айлын орон сууц, цэргийн клуб, цэргийн ангиудын байр, агуулах зэргийг барьж байв.

In accordance with resolution "On construction of the building for officer's school named after Sukhbaatar" of Ministers' Consil of the PRM on 28 February 1947 and order #145 of the Minister of Military Affiars, Deputy Commander-in-Chief on 1 July 1947, 26th Construction Battalion (017th unit of MAF) was established.

In the first year of its establishment, the unit built and repaired marshal Choibalsan's palace, building for Officer's school (recently University of Agriculture), ice-cellars in Ulaanbaatar and Undurkhaan, 16 dormitories, military club, building for military units, and kitchens.















МАХЦ энх цагийн байгуулалтад идэвхтэй оролцож үүргээ нэр төртэй биелүүлсэн юм.

The MPRMF actively participated in development and construction in peace time and fulfilled its duties respectfully.


РЕВОЛЮЦИОННАЯ МОНГОЛИЯ